



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг
томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 154 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Улаанбаатар Зүүн Азийн залуучуудын наадам зохион байгуулах хороо" хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

З.Төмөртөмөө	Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч бөгөөд "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадмыг зохион байгуулах хорооны дэд дарга
И.Баатархүү	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга бөгөөд "Улаанбаатар 2023" Зүүн Азийн залуучуудын наадмыг зохион байгуулах хорооны нарийн бичгийн дарга
Б.Баттүшиг	Үндэсний олимпын хороог төлөөлж буй Зүүн Азийн Олимпын хорооны Зөвлөлийн гишүүн, МҮОХ-ны тэргүүн дэд Ерөнхийлөгч
Ч.Наранбаатар	Үндэсний олимпын хорооны Ерөнхийлөгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Э.Бадар-Ууган	Үндэсний олимпын хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга
П.Буяндэлгэр	Хараат бус гишүүн
Б.Баттүшиг	Хараат бус гишүүн
Ч.Дарьсүрэн	Хараат бус гишүүн

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан "Улаанбаатар Зүүн Азийн Залуучуудын наадам зохион байгуулах хороо" ХК-ийн ТУЗ-ын ажиллах журмыг баталж, компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100101